

ЗООНОЗЫН ӨВЧИН СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВ							
ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ							
2022 ОН							
Шийдвэрийн д/д	Заалтын д/д	Шийдвэрийн нэр, огноо, дугаар	Холбогдох заалтын агуулга	Хэрэгжилтийн явц	Өөрийн үнэлгээ	Дээд шатны байгууллын үнэлгээ	Үнэлгээний тайлбар
МУ-ын хууль							
15	23	Төрийн албаны тухай /Шинэчилсэн найруулга/ 2017-12-07 Дугаар 2019.01.01	55.3. Төрийн байгууллага төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлнэ.	<p>Төрийн албаны тухай хууль, Эрүүл мэндийн ажилтны нийгмийн хамгааллын үндэсний хөтөлбөрийг хүрээнд ЗӨСҮТ-ээс 2022 онд хэрэгжүүлэх "Эрүүл, идэвхтэй амьдралыг төлөвшүүлэх, ажилтний нийгмийн баталгааг сайжруулах чиглэлээр хэрэгжүүлэх үйл ажиллагааны 5 бүлэг 19 арга хэмжээтэй төлөвлөгөө"-г Төвийн Ерөнхий захирлаар батлуулан 100 % хэрэгжүүлэн ажиллалаа. Төлөвлөгөөний хүрээнд дараах ажлуудыг зохион байгуулан ажиллалаа.</p> <p>Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - Ажилтан, албан хаагчдыг элэгний В, С вирусыг илрүүлэх, шинжилгээнд хамруулж, халдвар илрээгүй ажилтнуудыг дархлаажуулалтад үнэ төлбөргүй хамруулсан. - Мөн Гүзээгүй Монгол эр хүн, Эрчүүдийн эрүүл мэндийг хамгаалахад эмэгтэйчүүдийн оролцоо хөтөлбөрийн хүрээнд байгууллагын эмэгтэйчүүдийн санаачилгаар Moondance бүжгийн клубтэй хамтран сарын хугацаанд 40 гаруй ажилтан албан хаагч бүжгийн спортоор хичээллэсэн. - Ажилтан, албан хаагчдын дунд эрүүл мэндийн өдөрлөг зохион байгууллаа. Өдөрлөгөөр “Денк фарм” ХХК-ий эмч, төлөөлөгчдийг урьж, эрүүл мэндийн ерөнхий үзлэг хийж, ТАНИТА аппаратаар биеийн жин, галбир, дотор өөх, ерөнхий үзүүлэлтүүдийг гаргаж, SONOST-3000 аппаратаар ясны сийрэгжилтийг тодорхойлон, дүгнэж, зөвлөгөө мэдээлэл өгсөн. 	100		

				<ul style="list-style-type: none"> - Төвийн нийт ажилтнуудыг эрүүл ахуйн шаардлага хангасан, төвийн брэндбүүкэд суурилсан нэгдсэн загвар бүхий хувцас, хэрэгслээр тухай бүрт хангалтыг хийсэн. - 2022 онд ЗӨСҮТ-ийн дотоод журам болон бусад хууль, журмын хүрээнд 7 ажилтан албан хаагчдад төвийн Захирлын тушаалаар нэг удаагийн буцалтгүй тусламжийг олгосон байна. - Тасралтгүй сургалт нийт 13 удаа зохион байгуулагдаж давхардсан тоогоор 341 мэргэжилтэн сургалтад хамрагдсан. - Байгууллагын веб хуудас болон фэйсбүүк пейж хуудсаар дамжуулан төвийн үйл ажиллагааг тогтмол сурталчилан ажиллаж мэдээллүүдийг тухай бүр байршуулж байна. 			
7	21	Эрүүл мэндийн даатгалын тухай /Шинэчилсэн найруулга/ 2015-01-29 Дугаар 2015.01.29	<p>9.4.. Даатгуулагчийг урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо, шинжилгээ, халдварт өвчний эсрэг дархлаажуулалтад түүний нас, хүйс, эрүүл мэндийн эрсдэлд үндэслэн тогтоосон товлосон хугацаанд хамруулан, эрүүл мэндийн даатгалын сангаас зардлын төлбөрийг нь санхүүжүүлэх бөгөөд холбогдох журмыг санхүү, төсвийн болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн Үндэсний зөвлөл батална.</p>	<p>Зоонозын өвчин судлалын үндэсний төв нь эмч, мэргэжилтэн, ажиллагсдынхаа эрүүл мэндэд тогтмол хяналт тавьж жил бүр урьдчилан сэргийлэх үзлэгт оруулж, эрүүл мэндийн дүгнэлт гаргах, эрүүлжүүлэх ажил зохион байгуулан ажиллаж байна. Монгол улс даяар зохион байгуулагдан явагдаж буй урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ, оношилгоонд байгууллагын ажилтнууд хуваарийн дагуу харьяа дүүргийн эмнэлэгт 23 хүн хамрагдаж байна. Хамралт 20%-тай байсан тул ажилчдыг эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ, оношилгоонд бүрэн хамруулахаар ШУГТЭ-тэй хамтран ажиллалаа. ШУГТЭ-ийн эрт илрүүлгийн нэгжид 67 хүн эрт илрүүлэг, үзлэг шинжилгээнд хамрагдсан байна. Энэ онд нийт 90 хүн урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд хамрагдсан байна.</p> <p>Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгийн хамралтын сүүлийн 5 жилийн үзүүлэлт</p> <ul style="list-style-type: none"> • 2018 онд 88,4% • 2019 онд 95,1% • 2020 онд 71% • 2021 онд 91% • 2022 онд 92% тус тус хамрагдсан ба 5 жилийн дундаж 87,5% байна <p>Төвийн эмч, эмнэлгийн мэргэжилтэн, ажилтнуудын Гепатит “В”-гийн илрүүлэг, мөн “Covid-19” вакцинжуулалтын дараах дархлаа тогтоцыг судлах шинжилгээнд давхардсан тоогоор 110 ажилтнаас 4 удаа сорьц, цуглуулж, 167 ийлдсийг төвийн лавлагаа лабораторид шинжилж, Коронавируст халдвар (КОВИД-19)-ын дархлаа тогтоцыг тодорхойлов.</p>	100		

				<p>Мөн эмнэлзүйн шинж тэмдэг илэрсэнтэй 12 ажилтан, шинж тэмдэг илэрсэн ойрын хавьтал болсон 6 ажилтанд “COVID-19” -ийн PCR шинжилгээнд хамрагдсан. Коронавируст халдвар /Ковид-19/-ыг эрт илрүүлэх зорилгоор өглөө бүр төвийн эмч, ажилтнуудаас эмнэл зүйн асуумж судалгаа авч давхардсан тоогоор 3600 эмч, ажилтнууд хамрагдсан ба эмнэлзүйн шинж тэмдэг илэрсэн, ойрын хавьтал тогтоогдсон, сэжигтэй тохиолдлыг PCR шинжилгээнд хамруулан эмчилгээ оношилгооны талаар заавар, зөвлөгөөг тогтмол өгч ажиллаж байна.</p>			
--	--	--	--	---	--	--	--

21	62	<p>Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх,</p>	<p>7.1.4.. Цар тахлын үед халдварын голомтод болон эрсдэл бүхий нөхцөлд ажиллах байгууллага, ажилтныг шаардлагатай хамгаалалтын хувцас, хэрэгсэл, техник, багаж, тоног төхөөрөмжөөр хангах, мэдээлэл, сургалт, сэтгэл зүйн туслалцаа болон бусад дэмжлэг үзүүлэх, хөдөлмөрийн аюулгүй байдлын нөхцөл бүрдүүлэх, эдгээртэй холбоотой зардлыг шийдвэрлэх; (7.1.Цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах талаар Засгийн газар энэ хуулийн 11.1-д заасан шаардлагад нийцүүлэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:)</p>	<p>Цар тахлын үед халдварын голомтод болон эрсдэл бүхий нөхцөлд ажиллах байгууллага, ажилтныг шаардлагатай хамгаалалтын хувцас, хэрэгсэл, техник, багаж, тоног төхөөрөмжөөр хангах, мэдээлэл, сургалт, сэтгэл зүйн туслалцаа болон бусад дэмжлэг үзүүлэх, хөдөлмөрийн аюулгүй байдлын нөхцөл бүрдүүлэх, эдгээртэй холбоотой зардлыг шийдвэрлэх хүрээнд 2022 онд төсвийн хүрээнд ажилтан, албан хаагчдад 249.7 сая төгрөгийг Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн ажлын хувцас, нэг бүрийн хамгаалах хэрэгсэл, оношлуур, болон бусад шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгслийн багц, багаж тоног төхөөрөмж авч өгсөн. Ажилчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх зорилгоор нэмэлт үйл ажиллагааны орлогоос 235.0 сая төгрөгийг ажилчдад урамшууллаар олгосон. Мөн нийт ажилчдад нэг удаагийн дархлаа дэмжих бүтээгдэхүүн олгосон.</p>	100		
		<p>тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай 2020-04-29 Дугаар 2020.04.29</p>	<p>7.1.15. Цар тахлын болон нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед бэлэн байдлыг хангах, хариу арга хэмжээг авахад шаардлагатай хүнсний болон бусад нөөцтэй байх ба нөөцийн жагсаалтыг баталж, түүнийг бүрдүүлэхтэй холбоотой зардлыг шийдвэрлэх; (7.1.Цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах талаар Засгийн газар энэ хуулийн 11.1-д заасан шаардлагад нийцүүлэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:)</p>	<p>Коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахлын үед шаардлагатай эм эмнэлгийн хэрэгсэл, хувийн хамгаалах хэрэгсэл, ариутгал халдваргүйтгэлийн бодис, оношлуурын нөөцийн бүрдүүлж, мэдээллийг тухай бүр нь Эрүүл мэндийн яамны www.burtgel.mohs.gov.mn сайтад байршуулан, нөхөн хангалтыг ЭМЯ-нд тухай бүр уламжлан шийдвэрлүүлж, эмнэлгийн тусламж, үйлчилгээг тасалдалгүй үзүүлж байна. Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед бэлэн байдлыг хангах, хариу арга хэмжээг зохион байгуулахад шаардлагатай хүнсний болон бусад нөөцтэй байх ба нөөцийн жагсаалтыг баталж, түүнийг бүрдүүлэхтэй холбоотой 3 сараас доошгүй хугацааны зардлыг шийдвэрлэх шийдвэрийн хүрээнд нөөцөд байх эм эмнэлгийн хэрэгсэл, халдваргүйжүүлэлтийн бодис, оношлуурын нөөцийг бүрдүүлэн ажилласан. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - ЭМЯ-ны хандиваар Эрүүл мэндийн сайдын А/67, А/134, А/299, А/237, А/262 дугаар тушаалуудаар нийлүүлэгдсэн 178.7 сая төгрөгийн бараа материалын нөөц бүрдүүлэлтийг татан авч бүртгэлжүүлсэн. - ЭМЯ-ны хөрөнгө оруулалтаар Эрүүл мэндийн сайдын А/158, А/237, А254 дүгээр тушаалаар 1,039.8 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг хуваарилсан. - Хөрөнгө оруулалтаар 110,035.8 сая төгрөгийн бараа материал тус тус татан авч бараа материалын нөөцийг нэмэгдүүлэн ажилласан. 	100		

			<p>7.1.11.. Цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, эрүүл мэндээ хамгаалах арга замын талаар үнэн зөв, бодит мэдээллээр иргэдийг тогтмол, шуурхай, хүртээмжтэй хангах; (7.1.Цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах талаар Засгийн газар энэ хуулийн 11.1-д заасан шаардлагад нийцүүлэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:)</p>	<p>Зооноозын өвчний урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлэх мэдээллийг жилийн эцсийн байдлаар www.news.mn , www.eguur.mn ,www.olloo.mn , www.gogo.mn, www.eagle.mn, www.tovch.mn, www.chuhal.mn, www.mohs.gov.mn, www.mminfo.mn, www.monstame.mn, www.zarig.mn, www.zindaa.mn, www.inspection.gov.mn, www.ikon.mn, www.tsahiur.mn, www.arслан.mn, www.zuv.mn, www.dnn.mn, www.livetv.mn, www.ergelt.mn, www.mnb.mn, www.mpress.mn зэрэг 22 сайтаар 7 төрлийн сэдвийн хүрээнд давхардсан тоогоор 41 удаа мэдээ, мэдээлэл хүргүүлж ажилласан байна.</p> <p>Зооноозын шалтгаант халдварт өвчний цаг үеийн сэрэмжлүүлэх мэдээ, мэдээллийг www.news.mn , www.eguur.mn ,www.olloo.mn , www.gogo.mn, www.eagle.mn, www.tovch.mn, www.chuhal.mn, www.mohs.gov.mn, www.mminfo.mn, www.monstame.mn зэрэг 10 сайтаар 35 удаа түгээж ажилласан. Зооноозын өвчин судлалын үндэсний төвийн //www.facebook.com/nczd.gov/ фэйсбүүк хуудсанд 511 мэдээ нийтэлж хандалт 990536 байна. 2022 онд шинээр тарваган тахал 6, шумуул 2, хумхаа 4, шувууны томуу 1, бэтэг 5, галзуу 7, сармагчны цэцэг 5, токсоплазмоз 2, боом 5 нийт 37 инфографик шинээр хийж олон нийтэд түгээсэн байна.</p>	100		

			<p>MNB, 25TV, TV5, СүлдTV, C1, tenger TV, TV9, Mongol HD, SBN, NTV зэрэг 10 телевизэд “Галзуу”, “Зоонозын халдвар”, “Тарваган тахал”, “Хачгаар дамжих халдвар”, “Хумхаа”, “Зоонозын өвчний талаар”, “Сармагчны цэцэг өвчин” зэрэг сэдвийн хүрээнд их эмч нэвтрүүлэгт - 1, ёёо-г анагаах нь - 2, өнөө өглөө - 3, зочны цаг - 3 удаа нийт 9 нэвтрүүлэгт, цаг үеийн мэдээнд 20, нийт давхардсан тоогоор <u>29 удаагийн сэрэмжлүүлэг</u>, мэдээ, мэдээлэл түгээж ажиллалаа.</p> <p>Тайлангийн хугацаанд нийт 22 мэдээллийн сайт, 10 телевизтэй хамтран 80 удаа зоонозын халдвар, байгууллагын үйл ажиллагааны талаар мэдээ, мэдээллийг хүн амд хүргэсэн байна.</p> <p>Байгууллагын фэйсбүүк хуудасны дагагчийн тоо 2022 онд 18333 өмнөх жилийнхээс 34 хувиар өссөн үзүүлэлттэй, нийт 511 мэдээ нийтэлж 990,536 хандалт буюу өмнөх жилийн үзүүлэлтээс 59 хувиар өссөн үзүүлэлттэй байна.</p>			
69		<p>7.1.16. Цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх үйл ажиллагаанд ажлын тусгай горимоор томилогдон ажиллаж байгаа төрийн албан хаагчид нэмэгдэл, нэмэгдэл хөлс, нөхөх олговор, урамшуулал олгох асуудлыг шийдвэрлэх; (7.1.Цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах талаар Засгийн газар энэ хуулийн 11.1-д заасан шаардлагад нийцүүлэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:)</p>	<ul style="list-style-type: none"> - ЗӨСҮТ-ийн ажилчдын илүү цаг, нэмэгдэл хөлсийг ЭМДЕГ-ын 2021.08.06 ны К/06 дугаар гэрээ, ХНХЯ-ны 195 тоот тушаал, Сангийн сайдын 107 дугаар тушаал, 2022 оны ЗӨСҮТ-ийн Ерөнхий захирлын 2022 оны Б/17 дугаар тушаалуудыг мөрдлөг болгон цалин хөлс, илүү цагийн хөлсийг тооцоолон олгосон. Мөн эрүүл мэндийн ажилчдад олгох улирлын үр дүнгийн урамшуулалд 144.4 сая төгрөгийг хууль, тогтоол болон салбарын баримталж буй журмын хүрээнд батлагдсан төсвөөс санхүүжүүлэн тооцон олгосон. - Коронавируст (КОВИД-19) халдварын цар тахлын үед лабораторийн шинжилгээ, ариутгал халдваргүйтгэлийн үйл ажиллагаанд ажилласан ажилчдын илүү цагийн хөлсийг тухай бүр нь олгон ажиллаж байна. Өмнөговь аймгийн Шивээ Хүрэнд сэхээ боомтод томилогдон ажилласан мэргэжилтнүүдийг 6 ажилтанг сарын үндсэн цалингаар шагнаж урамшуулсан. - 2022 оны 06 сарын 01-нээс хойш Сангийн сайдын тушаалын дагуу хөдөө орон нутагт томилогдон ажиллаж байгаа мэргэжилтнүүдэд томилолтыг шинэчилсэн заавраар тооцоолон олгосон. 	100		

	70		<p>7.1.21. Цар тахлын халдвараар өвчилсөн, өвчилсөн байж болзошгүй хүнийг ялгаварлан гадуурхах, гутаан доромжлохоос урьдчилан сэргийлэх, ийм үйл ажиллагааг хуульд заасан аргаар таслан зогсоох;</p> <p>(7.1.Цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах талаар Засгийн газар энэ хуулийн 11.1-д заасан шаардлагад нийцүүлэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:)</p>	<ul style="list-style-type: none"> - Коронавируст халдвар /КОВИД 19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, эрүүл мэндээ хамгаалах арга замын талаар байгууллагын олон нийтийн сүлжээн дэх пэйж хуудсаар инфогарфик, сургалт сурталчилгааны материалыг тогтмол байршуулж үнэн зөв, бодит мэдээллээр иргэдийг тогтмол, шуурхай, хүртээмжтэй ханган ажиллаж байна. - Цар тахлын үед халдварт өртсөн ажилтныг удирдамж зааврын дагуу эмчилгээнд хамруулж тусгаарлан аливаа ялгаварлан гадуурхах асуудал гаргалгүй цалинг бүтэн олгон шаардлагатай дэмжлэг тусалцааг тухай бүр үзүүлсэн. - Нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах талаар Засгийн газраас гаргаж буй бодого шийдвэрийг дэмжин хэрэгжүүлж халдвар тархахаас сэргийлэн урьдчилан сэргийлэх оношлуур, эм, эмнэлгийн хэрэгслийн нөөцийг бүрдүүлэн ажиллаж байна. 			
	71		<p>9.1. Цар тахлын тохиолдол ажиглах, халдварыг илрүүлэх, оношлох, баталгаажуулах, мэдээлэх, халдвартай өвчтөнийг тусгаарлах, эмчлэх зэрэг шаардлагатай бусад хариу арга хэмжээний журмыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.</p>	<p>Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/257 дугаар тушаал "Коронавируст халдвар /КОВИД 19/-тай иргэнд тусламж, үйлчилгээ үзүүлэх чиглэл батлах тухай", 2021 оны А/29 дүгээр тушаал Коронавируст халдвар (Ковид-19)-ын тандалт, сэргийлэлтийн түр заавар болон бусад заавар зөвлөмж, чиглэлийн хүрээнд хэрэгжүүлэн ажиллаа. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - Эрүүл мэндийн сайдын 2020 оны 04 сарын 29- ний өдрийн А/269 дүгээр тушаалаар “Коронавируст халдвар (COVID-19)-ын түр заавар шинэчлэн батлах - Эрүүл мэндийн сайдын 2021 оны 04 сарын 28-ны өдрийн А/257 дугаар тушаалаар “Коронавируст халдвар (COVID-19)-тай иргэнд тусламж, үйлчилгээ үзүүлэх чиглэл батлах тухай <p>2022 он гарснаар Хилийн нэвтрүүлэх чадавхийг нэмэгдүүлэх чиглэлээр ЗГ-аас баримталж буй бодлогыг хэрэгжүүлж Өмнөговь аймгийн Шивээ Хүрэн Сэхээ боомтод 2 удаагийн ээлжээр 6 мэргэжилтэн ажиллаж 518 сорьц шинжилэхэд 4 эерэг тохиолдол бүртгэгдсэн. Хэрэгжиж буй хууль, тогтоомж, журмын дагуу дагуу хариу арга хэмжээг авч хэрэгжүүлсэн.</p> <p>2022 онд Монгол Улсын Шадар сайдын 2017 оны А/08 дугаар тушаалаар батлагдсан Эрсдэлийн үнэлгээний аргачлалын дагуу үнэлгээг салбар хоорондын байгууллагууд хамтран 29 удаа хийж гүйцэтгэв. Эрсдэлийн үнэлгээний аргачлалын дагуу “Монгол улсад коронавируст халдвар (КОВИД-19)-ын омикрон хувилбараар үүсгэгдсэн дэгдэлт гарсантай холбоотой “SARS-CoV-2 вирусийн омикрон хувилбараар үүсгэгдсэн халдварын улмаас үүсэх</p>	100		

			эрсдэл"-ийн үнэлгээг ХӨСҮТ тэргүүлж УОКШШ, ЭМЯ, ДЭМБ, ОБЕГ, МХЕГ, ГЕГ, НЭМҮТ, ТЕГ, ЗӨСҮТөв газрууд хамтарч оролцсон.			
75		9.5. Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага цар тахлын халдварын эмчилгээнд шаардлагатай шинэ төрлийн эм, ариутгал, халдваргүйтгэлийн бодисыг түргэвчилсэн журмаар бүртгэнэ.	<p>Коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахлын үед "Просан" халдваргүйжүүлэх бодисыг урьчилан сэргийлэх болон голомтын эцсийн халдваргүйжүүлэлтэд хэрэглэхээр Эрүүл мэндийн сайдын 2021 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн А/227 дугаар тушаалд санал оруулсан. А/227 дугаар тушаал хүчингүй болсон тул Эрүүл мэндийн сайдын 2021 оны 07 дүгээр сарын 08-ны өдрийн А/456 дугаар тушаалын 8 дугаар хавсралтад "Просан" халдваргүйжүүлэх бодисыг урьчилан сэргийлэх болон голомтын эцсийн халдваргүйжүүлэлтэд хэрэглэх заалтыг нарийвчлан судалж оруулсан. Коронавируст халдвар, урьдчилан сэргийлэх болон голомтын эцсийн халдваргүйжүүлэлтийг улсын хэмжээнд мөрдөж ажиллаж байна. Ариутгал халдваргүйтгэлийн чиглэлээр:</p> <p>Урьдчилан сэргийлэх халдваргүйтгэл 40710 м2, шавжгүйтгэл 9910 м2, мэрэгчгүйтгэл 9210 м2 талбайд, голомтын халдваргүйтгэл 12312 м2 талбайд хийсэн. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - LUX OIL рестораны 800 м2 талбайд урьдчилан сэргийлэх халдваргүйжүүлэлт, - Гэрээний дагуу боловсрол телевизийн 2000 м2 талбайд урьдчилан сэргийлэх халдваргүйжүүлэлт, - Кентавар, White house, Сүнжингранд Туушин, Наранбулаг, Рамада, Цэцэнхангай, Ibis, word Mongolia, Novitel, Corperate, Millenum 10 тусгаарлах байрны 30 өрөөнд 1932 м2 талбайд голомтын эцсийн халдваргүйтгэл 2 удаа, - Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэн, Шүүх эмнэлэгт, СБ, ЧД-ийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн газар, Эрүүгийн цагдаагийн газарт нийт 10380 м2 талбайд голомтын эцсийн халдваргүйжүүлэлт, - (КОВИД-19)-ийн батлагдсан тохиолдол гарсантай холбогдуулан оффисын өрөөнүүдэд 300 м2, узелийн өрөөнд эцсийн халдваргүйжүүлэлт, - Эрүүл мэндийн яаманд урьдчилан сэргийлэх халдваргүйжүүлэлтийг 500 м2 талбайн халдваргүйжүүлэлт, - Улсын их хурлын Тамгын газрын 3000 м2 талбайд урьдчилан сэргийлэх халдваргүйжүүлэлт, - Ноён пицца ХХК-тай хийсэн гэрээний дагуу 1, 2 -р улирлын халдваргүйжүүлэлт, шавжгүйтгэл, 	100		

				<p>мэрэгчгүйтгэлийн ажлыг 6 салбар төвийн 3310 м2 талбайн халдваргүйжүүлэлт,</p> <ul style="list-style-type: none"> - ОУ-ын хүүхдийн Найрамдал зусланд 7000м2 талбайд улирлын халдваргүйжүүлэлт, шавжгүйтгэл, мэрэгчгүйтгэл - Спортын төв ордонд “Парис-2024” зуны олимпийн наадмын эрхийн оноо олгох өндөр зэрэглэлийн тэмцээн зохион байгуулж байгаатай холбогдуулан халдваргүйтгэл хийсэн. Нийт талбай-4800 м² - Цагдаагийн ерөнхий газарт 5800 м2, Сүхбаатар дүүргийн цагдаагийн 1,2 хэлтэст 2200 м2 талбайд халдваргүйжүүлэлт хийсэн. - 05 дугаар цэргийн ангийн цэргийн байр, гал тогоо, соёлын төв, спорт ордон, төв байр, шалган нэвтрүүлэх хэсэгт нийт 6 объектод 14000 м2 талбайд эцсийн халдваргүйжүүлэлт хийж зөвлөгөө, зөвлөмж өгч хамтран ажилласан. - Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төвд мэрэгчгүйтгэл, шимэгчгүйтгэлийн ажлыг гэрээний дагуу 600 м2 талбайд шавжгүйтэл, мэрэгчгүйтгэл хийж гүйцэтгэсэн. - Капитал групп ХХК-ий 5 давхар 3500 м2 талбайд шавжгүйтгэл, халдваргүйжүүлэлтийн ажил хийж гүйцэтгэсэн. 			
УИХ-ын тогтоол							
65	<p>Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах талаар чиглэл өгөх тухай 2020-12-03 Дугаар 2020 №36</p>	<p>2.7/. Иргэд, олон нийтэд хувийн ариун цэврийг сахиж, хариуцлагатай байх, бусдын эрхийг хүндэтгэх талаарх мэдээлэл, сурталчилгааг идэвхжүүлэх;</p>	<p>Мэдээлэл, сурталчилгаа: МУЗГ, ДЭМБ, ЭМЯ, ХӨСҮТ, НЭМҮТ болон тус төвөөс боловсруулан гаргасан Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх бүхий л мэдээллийг олон нийтэд цахимаар болон боломжит сувгуудаар мэдээ, мэдээллүүдийг хүргэн ажиллаж байна.</p> <ul style="list-style-type: none"> - Коронавируст халдвар авч, өвчилсөн тохиолдолд гэрийн асаргаа сэдэвт инфографик 4 - Шинэ эмийн зөвлөмж 2 - Гар угаах, зай барих, маскаа зүүх, шинэ Омекрон хувилбараас сэргийлэх- 68 - Сургууль, цэцэрлэгт, сууц өмчлөгчдийн холбоодод халдваргүйжүүлэлт болон халдвар хамгааллын дэглэмийг сахих – 4 	100			

				Зэрэг нийт 78 инфографикийг "Зоонозын өвчин судлалын үндэсний төв" фэйсбүүк пэйж хуудсанд нийтэлж иргэд олон нийтэд түгээж, хандалт 146780 байна. Гараа зөв дараалаар угааж хэвшээрэй инфографикийг хийж, байгууллагын өрөө тасалгаанд нааж байршуулсан.			
УИХ-ын байнгын хорооны тогтоол							
34	94	Чиглэл өгөх тухай 2018-04-25 Дугаар 2018 №08 ЭЗБХ	2.2/. Төрийн захиргааны төв байгууллагуудын статистикийн мэдээ, мэдээллийн чанарыг сайжруулах, хамрах хүрээг өргөжүүлэх, төрийн мэдээллийн нэгдмэл сангийн сүлжээг байгуулах;	<p>Эрүүл мэндийн сайдын 2019-12-30 өдрийн А/611, А/126 дугаар тушаалуудыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд:</p> <ul style="list-style-type: none"> - Зоонозын халдвар өвчний сэжигтэй болон батлагдсан тохиолдлын мэдээг Эрүүл Мэндийн Хөгжлийн Төв, www.burtgel.mohs.mn сайтад өдөр бүр цахим хэлбэрээр мэдээллэн ажиллаж байна. - Зоонозын хүний өвчлөлийн мэдээг сар бүр ЭМХТ-д цахим хэлбэрээр нийт 12 удаа хүргүүлсэн. - Зоонозын халдварт өвчний тандалтын мэдээллийг салбар төвүүдээс өдөр бүр цуглуулж, өдөр тутмын мэдээг ЭМЯ хэрэгжүүлэн ажиллаж байна. - Коронавируст халдвар "КОВИД-19-ын сэжигтэй тохиолдол, бүртгэл, удирдлагын систем"-д өдөр бүр хүлээн авсан зоонозын шалтгаант тохиолдлын ОУ-ын өвчний ангиллын кодоор, аймгаар, өвчний нэршлээр, коронавируст халдварын үед ажилласан хүний нөөц, PCR шинжилгээнд хамрагдсан хүний тоон мэдээг өдөр бүр 09:00 цагт тогтмол хүргүүлэн ажиллалаа. - ЗӨСҮТ-ийн "ZIS буюу Зоонозын мэдээллийн систем" программыг нэвтрүүлж өдөр тутам болон сарын мэдээ тайланд тогтмол ашиглаж баяжилт хийгдэж байна. - Цахим мэдээллийн санг өргөтгөж хүлээн авсан дуудлага, тархвар судлалын хариу арга хэмжээ, голомтын мэдээ, эмнэлзүйн шинж тэмдэг лабораторийн шинжилгээний хариуг нэгтгэн оруулж холбогдох мэргэжилтнүүд тухай бүр хөтөлж, цахим технологийг хөгжүүлж байна. 2022 онд орон нутгийн ЗӨСТ-ийг тус программ хангамжид нэгтгэхээр төлөвлөн ажиллаж байна. - Төвийн үйл ажиллагааны тоон мэдээг үндэслэж, хагас бүтэн жилээр эргэн мэдээллийг боловсруулан гаргадаг. Эргэн мэдээлэл №17-г цаасан болон цахимаар гаргаж ЗӨСҮТ-ийн мэргэжилтэн, орон нутгийн ЗӨСТ, болон холбогдох мэргэжилтүүдийг мэдээллээр хангалаа. Мөн төвийн www.nczd.gov.mn сайтад байршуулан ил тод байдлыг ханган ажиллаж байна. 	100		

				- Зоонозын өвчний статистик мэдээллээр орон нутгийн ЗӨСТ болон мэргэжилтнүүдийг мэдээллээр тогтмол ханган ажиллаж байна.			
Ерөнхийлөгчийн зарлиг							
40	111	Монгол бичгийн хэрэглээг нэмэгдүүлэх ажлыг эрчимжүүлэх туйл 2018-05-23 Дугаар 2018_46	3. Албан байгууллага, аж ахуйн нэгж, барилга байгууламж, гудамж, талбайн нэр хаяг, бүтээгдэхүүний шошго, бэлгэ тэмдэг, зар сурталчилгаа зэргийг үндэсний бичгээр бичиж хэвшүүлэх ажлыг зохион байгуулах; үндэсний бичгийн хэрэглээг нэмэгдүүлж, түгээн дэлгэрүүлэхэд чиглэсэн уг үйл ажиллагаа, аливаа идэвх санаачилгыг хөхиүлэн дэмжиж, урамшуулж ажиллахыг бүх шатны Засаг дарга нар, холбогдох төрийн байгууллагуудад чиглэл болгосугай.	Үндэсний бичгийн хэрэглээг нэмэгдүүлж, түгээн дэлгэрүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг зохион байгуулах, идэвхи санаачилгыг дэмжих зорилгоор "Хөгжлийн чимээ" ТББ, "Монгол Улсын иргэний боловсрол сургах-судлах-сурталчилах төв" ТББ-уудтай хамтран ажиллаж, монгол бичгийн сургалтад байгууллагын ажилтан, албан хаагчдаас суралцуулахаар төлөвлөн, сургалтын үйл ажиллагаа, багц цаг, төлбөрийг судлан тодоод сургалтын төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлж байна.	80		
44	120	Засгийн газарт чиглэл өгөх тухай 2022-04-05 Дугаар 2022_43	1.4. Төрийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдээс зохион байгуулж буй албан ёсны баяр, ёслолын арга хэмжээ, хүлээн авалтад өндөр хатуулагтай этилийн спирт агуулсан архи, согтууруулах ундааг хэрэглэхийг бүрмөсөн хориглох;	Төвийн "Хөдөлмөрийн дотоод журам"-д архи согтууруулах ундааны зүйл хэрэглэхийг хориглосон заалтуудыг тусгасан бөгөөд албан ёсны баяр, ёслолын арга хэмжээ, хүлээн авалтад өндөр хатуулагтай этилийн спирт агуулсан архи, согтууруулах ундааг хэрэглэхийг бүрмөсөн хориглосон шийдвэрийг оруулж нийт ажилчдад дотоод сургалт болон шуурхай хурлаар танилцуулсан.	100		
	122		2. Нийт иргэн, аж ахуй нэгж, байгууллага архи, согтууруулах ундааны хэрэглээ, түүнээс үүдэлтэй эрүүл мэнд, нийгэм, эдийн засгийн сөрөг үр дагаврыг бууруулахад санаачилгатай оролцох, баяр ёслол, тэмдэглэлт өдөр, ажлын байранд өндөр хатуулагтай этилийн спирт агуулсан архи, согтууруулах ундааг хэрэглэхгүй байхыг уриалсугай.	Ажлын байранд, албан ажлаар гадуур ажиллах, томилолтоор ажил үүрэг гүйцэтгэж байх хугацаанд болон баяр ёслол, тэмдэглэлт өдөр архи согтууруулах ундааны зүйл хэрэглэхгүй байхыг байгууллагын "Хөдөлмөрийн дотоод журам"-аар зохицуулсан.	100		

ҮАБЗ-ийн зөвлөмж

46	129		<p>2. Биоаюулгүй байдлыг хангах салбар дундын зохицуулалтыг боловсронгуй болгох, энэ чиглэлээр ажилладаг төрийн захиргааны болон судалгаа шинжилгээний байгууллагын чадавхийг бэхжүүлэх,</p>	<p>- ЗӨСҮТ нь Монгол Улсын Цөмийн энергийн комиссын удирдлагаар Олон улсын атомын энергийн агентлаг (ОУАЭА)- аас хэрэгжүүлж буй “Зоонозын өвчний нэгдсэн арга хэмжээ” (ZODIAC project) санаачилгад хамрагдаж байна. Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд эрдэм шинжилгээ, гадаад хамтын ажиллагааны сүүлийн 10 жилийн мэдээллээр танилцуулга бэлтгэж уулзалтад оролцон мэдээлэл, санал солилцсон. Тус зөвлөлийн дэргэдэх Стратеги судалгааны хүрээлэнгээс 05 дугаар сарын 13-нд зохион байгуулсан МУ-ын Ерөнхийлөгчийн санаачилгаар бичигдэж буй “Монгол улсын үндэсний аюулгүй байдал” номын хүрээлэн буй орчны салбарын хэлэлцүүлэгт оролцож санал солилцсон.</p> <p>- Биоаюулгүй байдлыг хангах салбар дундын зохицуулалтыг боловсронгуй болгох, энэ чиглэлээр ажилладаг төрийн захиргааны болон судалгаа шинжилгээний байгууллагын чадавхийг бэхжүүлэх зөвлөмжийн хүрээнд Биоаюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны 2022-2024 онд хэрэгжүүлэх хөтөлбөрийн төслийг 12 бүлэг үйл ажиллагааг төлөвлөсөн төлөвлөгөөний төслийг ЭМЯ-ны НЭМГ-ын Халдварт өвчний хэлтэст цахимаар хүргүүлсэн. Мөн төв нь Эрүүл мэндийн яамны Лабораторийн салбар зөвлөлтэй хамтран биологийн эрсдэл бүхий илгээмж, биобэлдмэл тээвэрлэх, хадгалах журмыг боловсруулж, батлуулан, мөрдөн ажиллаж байна. Нийслэл, аймгийн ЗӨСТ-үүдэд хүргүүлсэн.</p> <p>- Био-аюулгүй ажиллагаа, биохамгаалал сайжруулах сарын аяны хүрээнд Төвийн лабораторид хөтлөгдөж байгаа анхан шатны бүртгэл маятын хөтлөлтөд хяналт тавьж илэрсэн үл тохирлыг арилгасан.</p> <p>- Химийн хортой болон аюултай бодис ашиглах тусгай зөвшөөрөл авахаар нийт 292 химийн бодисын Химийн хор аюулын лавлах мэдээллийг гаргасан. Химийн бодисын болзошгүй байдлын төлөвлөгөөг боловсруулсан. Түүнчлэн Хар тамхи мансууруулах бодистой тэмцэх газраас “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодис” ашигладаг лаборатори, байгууллагыг урьдчилсан байдлаар үнэлэх үнэлгээний шалгалтад химийн лабораторийг танилцуулж</p>	100		
----	-----	--	--	--	-----	--	--

үнэлгээний хуудсын дагуу 23 хуудас материал бүрдүүлж явуулсан.

- Европын Холбооны Хими, биологи, цацраг идэвхт болон цөмийн эрсдэлийг бууруулах (CBRN CoE санаачилга) санаачилга, Олон улсын шинжлэх ухаан технологийн төв (ISTC)-өөс хэрэгжүүлж буй P53 төслийн хүрээнд :

- "Sanitary control/risk assessment training for medical facilities and laboratories" сэдэвт сургалтад 2 мэргэжилтэн суралцсан.

- Европын Холбооны Хими, биологи, цацраг идэвхт болон цөмийн эрсдэлийг бууруулах (CBRN CoE санаачилга) санаачилга, Олон улсын шинжлэх ухаан технологийн төв (ISTC)-өөс хамтран хэрэгжүүлж эхэлж буй "Нийтийг хамарсан арга хэмжээний үеийн бэлэн байдал, хариу арга хэмжээ", P87 төслийн хүрээнд 4 дүгээр сарын 4-10-нд Узбекистан улсын Ташкент хотноо зохион байгуулагдсан сургалт-семинарт төвийн 2 мэргэжилтэн оролцож сургагч багшийн гэрчилгээг авсан.

- Төв Ази, Кавказын Биоаюулгүй байдлын Холбоо (ТАКББХ), Европын холбоо, Европын Холбооны Хими, биологи, цацраг идэвхит болон цөмийн эрсдэлийг бууруулах (CBRN CoE санаачилга) санаачилга, Олон улсын шинжлэх ухаан технологийн төв" хамтран Гүрж улсын Тбилиси хотноо 2022 оны 10 сарын 3-7 -нд "КОВИД-19: Сургамжууд" олон улсын сургалт болон бага хуралд 2 мэргэжилтэн оролцож илтгэл хэлэлцүүлсэн.

2022 онд нийт тарваган тахал өвчний сэжигтэй 6 тохиолдол бүртгэгдсэнээс 3 удаа, боом өвчний сэжигтэй 4 тохиодол бүртгэгдсэнээс 2 удаа нийт 5 удаа эрсдэлийн үнэлгээ хийж, эргэн мэдээлэл, зөвлөмжөөр ханган ажилласан.

2022 онд Монгол Улсын Шадар сайдын 2017 оны А/08 дугаар тушаалаар батлагдсан Эрсдэлийн үнэлгээний аргачлалын дагуу үнэлгээг салбар хоорондын байгууллагууд хамтран 29 удаа хийж гүйцэтгэв. Эрсдэлийн үнэлгээний аргачлалын дагуу "Монгол Улсад коронавируст халдвар (КОВИД-19)-ын омикрон хувилбараар үүсгэгдсэн дэгдэлт бүртгэгдсэнтэй холбоотой "SARS-CoV-2 вирусийн омикрон хувилбараар үүсгэгдсэн халдварын улмаас үүсэх эрсдэл"- ийн үнэлгээг ХӨСҮТ тэргүүлж УОКШШ, ЭМЯ,

				<p>ДЭМБ, ОБЕГ, МХЕГ, ГЕГ, НЭМҮТ, ТЕГ, ЗӨСҮТ зэрэг байгууллагууд хамтарч оролцов. Эрсдэлийн үнэлгээнд магадлалын түвшин тогтоох 19 асуултаас 12 (63.1%) тийм, Үр дагаврын түвшин тогтоох 18 асуултаас 8 (44.4%) тийм гэсэн хариулттай эрсдэлийн үнэлгээний дүн ДУНД ЭРСДЭЛТЭЙ үнэлэгдлээ.</p>			
128		6. Молекул биологи, биоанагаах, биотехнологи, нано технологийн чиглэлээр мэргэжилтэн бэлтгэх, тэдгээрт ажлын байрыг бодлогоор бий болгох	<p>Молекул биологи, биоанагаах, биотехнологи, нано технологийн чиглэлээр мэргэжилтэн бэлтгэх, тэдгээрт ажлын байрыг бодлогоор бий болгох</p> <ul style="list-style-type: none"> - Тус төвд Молекул биологийн чиглэлээр 2 генетикч, 1 судлаач биоанагаахын мэргэжилтний бүрэлдэхүүнтэйгээр иж бүрэн тоноглогдсон молекул биологийн лаборатори, сургалтын лабораториуд ажиллаж байна. - WHO The Public Health Laboratories Webinar Team–ээс зохион байгуулсан “SARS-CoV-2 variants, Emergency Use Listing (EUL) and diagnostics performance monitoring” сургалтад цахимаар ажилчид оролцсон. - ХӨСҮТ-ийн Вирус судлалын лабораторид “SARS-CoV-2 вирусын бүрэн геномын дараалал тогтоох NGS шинжилгээний арга” сургалтад 3 мэргэжилтэн 5 хоног сууж, арга зүйн анхан шатны мэдлэг эзэмшсэн. - Quick Mobile төхөөрөмжийг ашиглан орон нутгийн лабораториудад ПГУ тавих арга зүйг амжилттай туршиж зоонозын гаралтай 10 халдварыг ПГУ-аар 14 аймгийн ЗӨСТ-үүдэд оношлох боломжтой болсон. - “Зоонозын өвчин судлалын төвийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний үйл ажиллагаанд зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх” ажлын удирдамжийн дагуу Өвөрхангай, Баянхонгор, Говь-Алтай, Ховд, Баян-Өлгий, Увс, Архангай аймгийн ЗӨСТ-ийн лабораторийн үйл ажиллагаанд үнэлгээ зөвлөмж өгч ажилласан. Уг үйл ажиллагааны үеэр Баянхонгор, Баян-Өлгий, Увс аймгийн ЗӨСТөвийн лабораторийн эмч, лаборант нийт 11 хүнд хачигт халдварыг ФХУ-ын аргаар оношлох сэдвээр ажлын байрны дадлагажих сургалт зохион байгуулсан. Эрхүү хот дахь Тарваган тахал судлалын эрдэм шинжилгээний хүрээлэнгээс зохион байгуулсан мэргэжил дээшлүүлэх сургалтад ЗӨСҮТ-өөс 6, Архангай, Баянхонгор, Сэлэнгэ, Увс аймгийн ЗӨСТ-өөс 4, нийт 10 мэргэжилтэн хамрагдаж тарваган тахал болон бусад гоц халдварт өвчний лабораторийн оношилгоо, халдвар судлал, 	100			

				урьдчилан сэргийлэх арга хэмжээний орчин үеийн арга зүйд суралцсан. - ОХУ-ын Саратов хот дахь Тарваган тахал эсэргүүцэн судлах "Микроб" хүрээлэнд "Нян судлал, гоц аюултай халдварын үүсгэгчтэй ажиллах аюулгүй ажиллагааны үндэс" сэдэвт 325 цагийн сургалтад 2 мэрэгжилтэн гэрчилгээ авсан.			
ЗГ-ЫН ТОГТООЛ							
141		Төрийн албаны сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай 2018-08-22 Дугаар 2018_258	1.3. төрийн албан хаагчдын ажлын байрны шинжилгээ хийж, шинжилгээний дүнд тулгуурлан байгууллагын чиг үүргийн давхардал, хийдлийг арилгаж, ажлын бүтээмж, үйл ажиллагааны уялдаа холбоог сайжруулах;	- Төвийн нийт ажилтан албан хаагчдын "Албан тушаалын тодорхойлолт"-уудыг алба, тасгийн дарга нарын саналыг үндэслэн шинэчлэн боловсруулан, баталгаажуулж, ажлын давхардал хийдлийг арилгах арга хэмжээг зохион байгуулж албан тушаалын тодохойлолтод тусгайлан боловсруулж тусгаж оруулан ажилтан нэг бүрт танилцуулсан. - Чиг үүргийн давхардал хийдлийг арилгах зорилгоор декриттэй байгаа болон сул орон тооны ажил үүрэг мөн тусгайлсан чиг үүргийг /Шуурхай удирдлагын нэгжийн зохицуулагч, албаны дарга, алба тасгийн бага эмч, / 13 ажилтан, албан хаагчдаар хавсруулан гүйцэтгүүлж байна. - Төвийн ажил, дүгнэх байнгын комиссыг төвийн захирлын 2021 оны А/11 дүгээр тушаал батлуулж, ажлын бүтээмж, үйл ажиллагааны уялдаа холбоог сайжруулах зорилгоор сар бүр ур чадварын үнэлгээг хэлэлцүүлж, Удирдлагын зөвлөлийн хурлаар шийдвэрлүүлэн баталгаажуулж, ажилчдад ур чадварын нэмэгдлийг тодорхой хувиар олгон ажиллаж байна.	100		
162			1.6. Төрийн жинхэнэ албан хаагч жирэмсний болон амаржсны амралттай байгаа, эсхүл 3 сараас дээш хугацааны сургалтад хамрагдаж сул орон тоо гарснаас бусад тохиолдолд төрийн албаны сул орон тоонд гэрээт ажилтан томилохгүй байх зарчим баримталж, төрийн байгууллагад албан ажлын зайлшгүй шаардлагыг үндэслэн богино хугацаагаар ажиллуулахаас бусад тохиолдолд гэрээт ажилтан ажиллуулахгүй байх;	Эрүүл мэндийн сайдын 2019 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн "Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн бүтэц, дүрэм, шинэчлэн батлах тухай" А/310 дугаар тушаалын дагуу төвийн батлагдсан орон тоонд гэрээт ажилтны 2 орон тоо тусгагдсаныг үндэслэн Эрдэмтэн нарийн бичиг, Гадаад харилцаа хариуцсан ажилтныг албан ажлын зайлшгүй шаардлагаар гэрээгээр ажиллуулж байна.			

	163		<p>1.7. Төрийн албан хаагч албан томилолтын явцад, ажлын болон ажлын бус цагаар ажлын байранд согтууруулах ундаа хэрэглэх явдлыг таслан зогсоох, төрийн байгууллагын байр, ажлын байранд согтууруулах ундаа, мансууруулах бодис, галт болон хүйтэн зэвсэг, тэсэрч дэлбэрэх болон шатамхай бодис, хэрэгслийг нэвтрүүлэх, хадгалах, хэрэглэх, ашиглахыг байгууллагын дотоод журамд тусган хориглож, зөрчсөн тохиолдолд хариуцлага тооцох;</p>	<p>Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 09 дүгээр сарын 26-ны өдрийн тогтоолоор тус төв нь Цагдаа, Дотоодын цэргийн хамгаалалтад авах улсын онц чухал объект тул дотоодын цэргийн 05 дугаар ангитай харуул хамгаалалтын гэрээ, хамтын ажиллагааны төлөвлөгөө боловсруулан баталгаажуулж, хамтран ажилладаг. Байгууллагад ажлын байранд согтууруулах ундаа, мансууруулах бодис, галт болон хүйтэн зэвсэг, тэсэрч дэлбэрэх болон шатамхай бодис, хэрэгслийг, хадгалах, хэрэглэх, ашиглах нэвтрүүлэхийг хориглож, түүнд бүрэн хяналт тавьж ажилладаг бөгөөд үүнтэй холбоотой зохицуулалтыг хөдөлмөрийн дотоод журам, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хамтарсан зөвлөлийг төвийн хэмжээнд байгуулан ажил үүрэгт тус тус тусган мөрдлөг болгон ажиллаж байна. 2022 онд зөрчил, гэмт хэрэг бүртгэгдээгүй болно.</p>	100		
	164		<p>1.8. Төрийн албан хаагчдын үйлдсэн гэмт хэрэг, гаргасан зөрчил, сахилга, ёс зүйн зөрчилд судалгаа, дүн шинжилгээ хийж, шалтгаан нөхцөлийг тогтоон, урьдчилан сэргийлэх арга хэмжээг үр дүнтэй зохион байгуулах;</p>	<p>Төвийн албан хаагчийн гаргасан алдаа зөрчлийг тухай бүр дотоод хяналт шалгалт, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөл, ёс зүйн байнгын хороо, Дотоодын цэргийн 05 дугаар ангитай байгуулсан хамтын ажиллагааны гэрээ, төлөвлөгөөний хүрээнд илрүүлж холбогдох арга хэмжээг Удирдлагын зөвлөлийн хуралд танилцуулж, Хөдөлмөрийн тухай хууль, төвийн хөдөлмөрийн дотоод журамд нийцүүлэн арга хэмжээ авч ажилласан. 2022 онд сахилгын шийтгэл оногдуулсан 6 ажилтан байна. Мөн ажил үүргээ гүйцэтгэж явах үедээ зөрчил гаргасан ажилтнуудад төвийн шуурхай хурлаар сануулж алдаа зөрчлийг арилгах арга хэмжээ авч, үр дүнг танилцуулахаар үүрэг даалгавар өгсөн.</p>	100		
	165		<p>1.9. Төрийн байгууллагад ажлын цаг ашиглалтыг хурууны хээний болон камерын хяналтын системээр байнга бүртгэж, түүнд тавих хяналтыг сайжруулах;</p>	<p>Ажилтнуудын ажлын цагийн ирц, хоцрогдол, цаг ашиглалтыг сайжруулах зорилгоор Төвийн хашаагаар нэвтрэн орох, гарах бүх хөдөлгөөнд бичил дамжуулагчтай ажлын үнэмлэхийг уншуулж орж, гарах байдлаар зохицуулалтыг хийж, тогтмолжуулсан бөгөөд сар бүр алба, тасгийн дарга нарт мэдээлж, цалин урамшуулалтай уялдуулсан үнэлгээжүүлэх зохион байгуулалтыг хийн ажиллаж байна.</p>	100		

	166		1.10. Ажлын байран дахь бүх хэлбэрийн хууль бус дарамт шахалт, ялгавартай хандах үйлдлийг таслан зогсоож, ийм үйлдэл гаргасан албан тушаалтанд хүлээлгэх хариуцлагын талаар байгууллагын дотоод журамд тусган мөрдүүлж, эерэг уур амьсгалтай, сэтгэл зүйн дарамтгүй ажиллах орчныг бүрдүүлэх арга хэмжээ авах;	Төвийн хөдөлмөрийн дотоод журамд ялгаварлан гадуурхалт, дарамт шахалтаас урьдчилан сэргийлэх талаар тусгаж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Ажлын байран дахь хууль бус дарамт, шахалт, ялгавартай хандах, үйлдэлтэй холбоотой зөрчил илрээгүй. Мөн ажилчдын улирлын сэтгэл ханамжийн судалгааг тогтмол авч, үр дүнд суурилсан үйл ажиллагааг тухай бүр төлөвлөж, улирдагын зөвлөлөөр хэлэлцүүлэн үүрэг даалгавар өгч хэрэгжүүлэн ажиллаж байна.	100		
	167		3.. Төрийн албаны соёл, дэг журмыг сахиулах, ажлын цаг ашиглалт, ажлын бүтээмжийг дээшлүүлэх зорилгоор гэнэтийн болон төлөвлөгөөт хяналт шалгалтыг холбогдох байгууллагатай хамтран төрийн байгууллагуудад тогтмол зохион байгуулж байхыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Г.Занданшатар, өөрийн эрхлэх асуудлын хүрээний Засгийн газрын агентлаг, төрийн бусад байгууллагад хэрэгжүүлэхийг Засгийн газрын гишүүд, бүх шатны Засаг дарга, Засгийн газрын агентлагийн дарга, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дарга нарт тус тус даалгасугай.	Ажилтнуудын ажлын цагийн ашиглалтыг сайжруулах, бүтээмжийг нэмэгдүүлэх, үйл ажиллагааны хэрэгжилтийг хангах зорилгоор алба, тасаг нэгжийн дарга нар хяналтын тойролт /обход/-оор ажиллаж хэвшсэн. Ажлын бүтээмжид голлон анхаарч 7 хоногийн ажлын төлөвлөлт гүйцэтгэлийг хэвшүүлэн тайлангийн тооноос чанарт анхаарах шатанд хүрч, гүйцэтгэлийг үнэлэн 7 хоногийн даваа гараг бүрийн шуурхай хуралд тогтмол танилцуулан ажиллаж байна.	100		
68	186	Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай 2020-01-08Дугаар 2020_10	3.. Төрийн болон орон нутгийн өмчийн үл хөдлөх хөрөнгийн дахин үнэлгээгээр үнэ цэнийн бууралттай үнэлэгдсэн барилга байгууламжийн үнэлгээ, төсвийн зардал, чанар байдлыг нягтлан үзэж, шаардлагатай тохиолдолд залруулах, зөрчил гаргасан албан тушаалтанд зохих журмын дагуу хариуцлага тооцохыг холбогдох төсвийн	Төрийн болон орон нутгийн өмчийн үл хөдлөх хөрөнгийн 2018 оны дахин үнэлгээгээр барилга байгууламжийн үнэлгээнд өөрчлөлт ороогүй бөгөөд тайлан балансад өөрчлөлт ороогүй болно.	100		

			ерөнхийлөн захирагч нарт даалгасугай.			
66	167	Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 2022-05-25 Дугаар 2022_203	<p>31. 1. Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх зорилгоор дараахь арга хэмжээ авч ажиллахыг бүх шатны төсвийн захирагч, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн дарга, захирал, эрхлэгч нарт тус тус үүрэг болгосугай:</p> <p>1.1. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 5.1, 5.2-т заасны дагуу тэргүүн дэд, дэд, орлогч даргатай байхыг хориглосон төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчийн хуулийн этгээдийн холбогдох албан тушаалтныг ажлаас чөлөөлөх арга хэмжээ авч, тэтгэмжийг зохих журмын дагуу шийдвэрлэх;</p> <p>1.2. Жил бүрийн төсвийн төслийн талаарх саналаа Төрийн хэмнэлтийн тухай хуульд нийцүүлсний үндсэн дээр хөрөнгө оруулалтын болон урсгал зардлыг төлөвлөж, эрх бүхий этгээдэд хүргүүлэх;</p> <p>1.4. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13.3, 13.4 дэх хэсгээр хориглосон хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний зураг, төсөв, техник, эдийн засгийн үндэслэлийг 2022 онд боловсруулахгүй, энэ</p>	<ul style="list-style-type: none"> - Хуулийн хугацаанд 2023 оны төсвийн төсөөлөл болон хөрөнгө оруулалтын саналаа хүргүүлсэн. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн дагуу тэвчиж болох үргүй зардал, хуулийн 13.3, 13.4 дэх хэсгээр хориглосон хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээ тусгаагүй болно. - Хуулийн хэрэгжилт бүрийг бусад холбогдох хууль тогтоомж, журамтай уялдуулан ханган ажиллаж байна. Байгууллагын үндсэн чиг үүрэгт шууд хамаарах Олон улсын түвшний сургалтыг олон улсын байгууллагын санхүүжилтээр зохион байгуулсан. - Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13.3, 13.4 дэх хэсгээр хориглосон хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээ тусгаагдаагүй болно. 		

			чиглэлээр төсвөөс хөрөнгө зарцуулахгүй байх.			
67	169	Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 2022-05-25 Дугаар 2022_204	<p>1. Автомашины хэрэглээг хуулиар хязгаарласантай холбогдуулан суудлын автомашин ашиглах эрх бүхий албан тушаалтнаас бусад албан тушаалтны албан хэрэгцээнд ашиглагдаж байгаа, төрийн өмчид бүртгэлтэй автомашины талаарх дэлгэрэнгүй мэдээллийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт, орон нутгийн өмчид бүртгэлтэй автомашины талаарх мэдээллийг аймаг, нийслэлийн Засаг даргад тус тус хүргүүлж, тогтоосон хугацаанд батлагдсан хуваарийн дагуу заасан байршилд татан төвлөрүүлж, зохих журмын дагуу хүлээлгэн өгөх арга хэмжээ авахыг бүх шатны төсвийн захирагч, төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой хуулийн этгээдийн гүйцэтгэх захирал, төсвөөс санхүүжилт авдаг бүх байгууллагын дарга нарт тус тус даалгасугай.</p>	<p>Тус Төвд нийт 16 тээврийн хэрэгсэл, нэг лаборторийн зориулалттай чиргүүл ашиглагдаж байгаа бөгөөд тусламж үйлчилгээний бэлэн байдлаа ханган хуваарийн дагуу сорьц тээвэрлэх, зоонозын халдварт өвчний сэжигтэй мэрэгч, амьтан хүний дуудлага, үйл явдал бүртгэгдсэн үед шуурхай хариу арга хэмжээг зохион байгуулах, ариутгал халдваргүйтгэлийн дуудлага зэрэг эмнэлгийн болон нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд ашиглагддаг.</p> <ul style="list-style-type: none"> - 2022 оны байдлаар 7 автомашин, 1 автолаборатори хээрийн тандалт судалгаанд Дорнод, Ховд, Увс, Өвөрхангай, Дорноговь, Сэлэнгэ, Орхон, Дархан-Уул, Говь-алтай, Баянхонгор, Төв аймгуудад тус тус ажилласан. - МУЗГ-ын шийдвэрээр 1 автолаборатори Шивээ Хүрэн боомтод ажилласан. - 2022 онд ЭМЯ-ны хөрөнгө оруулалтаар туулах чадвар сайтай Toyota, Land Cruiser 78 машинаар парк шинэчлэлт хийгдсэн. 	100	

	170		<p>9. Автомашины хэрэглээг хязгаарласан, автомашин төвлөрүүлэн, шилжүүлсэнтэй холбогдуулан жолооч нарыг үргэлжлүүлэн ажиллуулах, шаардлагатай бол шилжүүлэн байршуулах, ингэхдээ тэдний орлого, нийгмийн баталгааг одоо байгаа түвшнээс бууруулахгүй байх арга хэмжээг холбогдох хууль тогтоомжийн дагуу авч хэрэгжүүлэхийг бүх шатны төсвийн захирагч, төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой хуулийн этгээдийн гүйцэтгэх захирал, төсвөөс санхүүжилт авдаг бүх байгууллагын дарга нарт тус тус даалгасугай.</p>	Одоогоор шилжүүлэх болон шилжүүлэх шаардлагатай авто машин байхгүй.	100		
68	171	<p>Монгол хэлний тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 2023-01-05 Дугаар 2022_7</p>	<p>5. Монгол хэлний тухай хуулийн хэрэгжилтийг хангах дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг төсвийн ерөнхийлөн болон шууд захирагч нарт тус тус даалгасугай:</p> <p>5.4. төрийн албан хаагчдын монгол хэл, үндэсний бичгийн мэдлэг чадварыг дээшлүүлэх арга хэмжээ авах, сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг жил бүр баталж мөрдүүлэх;</p> <p>5.5. төрийн байгууллагын гадна болон өрөө тасалгааны хаяг, албан хаагчдын нэрийн хуудсыг монгол бичгээр үйлдэж, хэвшүүлэх.</p>	<p>Үндэсний бичгийн хэрэглээг нэмэгдүүлж, түгээн дэлгэрүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг зохион байгуулах, идэвх санаачилгыг дэмжих зорилгоор "Хөгжлийн чимээ" ТББ, "Монгол Улсын иргэний боловсрол сургах-судлах-сурталчилах төв" ТББ-уудтай хамтран ажиллаж, монгол бичгийн сургалтад байгууллагын ажилтан, албан хаагчдаас суралцуулахаар төлөвлөн, сургалтын үйл ажиллагаа, багц цаг, төлбөрийг судлан дотоод сургалтын төлөвлөгөөнд тусган нийт ажилчдыг хамруулахаар ажиллаж байна. Цаашид байгууллагын гадна болон өрөө тасалгааны хаяг, цахим хуудаст нийтлэгдэж буй мэдээ мэдээллийг үндэсний бичгээр зэрэгцүүлэн нийтлэх, байгууллагын шийдвэр, албан бичгийг хос бичгээр хөтлөх ажлыг турших талаар төлөвлөсөн.</p>	100		
Ерөнхий сайдын захирамж							
ЗГ-ын хуралдааны тэмдэглэл							

94	205	<p>2021 оны 9 дүгээр сарын 15-ны өдөр 51 дүгээр тэмдэглэл 2021-09-15 Дугаар 2021_51</p>	<p>Х.3. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээний гүйцэтгэл болон санхүүжилтийн төрийн сан дахь гүйлгээний явц байдлын талаар Сангийн сайд Б.Жавхлан Засгийн газрын гишүүдэд танилцуулав.</p> <p>Үүнтэй холбогдуулан дараахь арга хэмжээ авахыг холбогдох албан тушаалтанд даалгав:</p> <p>1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийн хянан баталгаажуулалт болон санхүүжилтийн гүйлгээг гүйцэтгэгч нарт олгох явцыг үндэслэлгүйгээр удаашруулж, хувийн хэвшлийн аж ахуйн нэгжид учруулж буй хүнд суртлыг таслан зогсоохыг захиалагч, захиалагчийн хяналтыг хэрэгжүүлж байгаа байгууллага, бүх шатны төсвийн захирагч нарт;</p> <p>4. Засгийн газрын 2021 оны 160 дугаар тогтоолоор батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-д заасан хатуу баримтлан улсын төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийн гүйлгээг шилжүүлэхийг бүх шатны төсвийн захирагч нарт;</p>	<ul style="list-style-type: none"> - Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж байгаа 5 арга хэмжээний гүйцэтгэлийн хянан баталгаажуулалтад ямарваа нэгэн хүнд суртал, удаашруулсан байдал гаргаагүй бөгөөд гүйцэтгэгч байгууллагуудаас гомдол санал ирээгүй болно. - “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын дагуу Худалдан авах ажиллагааны нэг төсөл арга хэмжээний гүйцэтгэлийг үндэслэн 2 удаа гүйлгээ хийгдэж, гэрээний зөрчилгүй бараа бүтээгдэхүүн нийлүүлэгдэж байна. - Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээ одоогоор тус төвд хэрэгжээгүй болно. ЭМЯ, ЗӨСҮТ-ийн Эм, эмнэлгийн хэрэгслийн нөөцийн агуулах хугацаандаа баригдаж улсын комисс хүлээн авсан. 	100		
----	-----	---	--	---	-----	--	--

153	303	<p>2021 оны 10 дугаар сарын 13-ны өдөр 55 дугаар тэмдэглэл 2021-10-13 Дугаар 2021_55</p>	<p>ХҮ.9.2. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2022 онд шинээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл, арга хэмжээний эрх шилжүүлэх болон худалдан авах ажиллагааны төлөвлөгөө боловсруулж батлуулах асуудлыг ирэх оны төсөв батлагдсан даруйд шийдвэрлүүлж, холбогдох байгууллагад хүргүүлэх, худалдан авах ажиллагааны гүйцэтгэгчийг сонгох тендер шалгаруулалтыг зарлаж 2022 оны 4 дүгээр сарын 1-ний өдрийн дотор зохион байгуулж дууссан байхаар тооцож, бэлтгэл хангахыг бүх шатны төсвийн захирагч нарт даалгав;</p>	<p>Монгол Улсын Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 47 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн хүрээнд 2022 оны төвийн захирлын А/03 дугаар тушаалаар төвийн 5, хөндлөнгийн 2 гишүүний бүтэцтэйгээр үнэлгээний хороог байгуулж, хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсвийн хүрээнд худалдан авах ажиллагааг зохион байгуулан ажиллалаа. Тус төвийн оношзүйн тусламж, үйлчилгээтэй холбоотой нийт 320,000,000 төгрөгийн өртөг бүхий оношлуур, урвалж, химийн бодис, тэжээлт орчныг худалдан авахаар ийлдэс судлалын шинжилгээний оношлуур болон бусад, молекул биологийн оношлуур, химийн бодис гэсэн 3 багцад хуваан нээлттэй тендер зарлаж, 2 болон 3 дугаар багцуудын тендерт гүйцэтгэгч шалгарч гэрээ байгуулан төлөвлөгөөний дагуу нийлүүлэгдэж байна. 2022 онд 1 дүгээр багц буюу ийлдэс судлалын оношлуурын тендерийг 2 удаа зарласан боловч, амжилтгүй болсон тул шууд гэрээ байгуулан худалдан авах ажиллагааг зохион байгуулахаар шийдвэрлэсэн. Үүнтэй холбоотой Монгол улсад цөөн тоогоор хэрэглэгддэг зоонозын болон дамжуулагчаар дамжих халдварын оношлуур урвалж, нийлүүлэгдэхгүй байгааг ЭМЯ-нд уламжилж, ЭЭХХЗГ, ХӨСҮТ, ЗӨСҮТ, нийлүүлэгч аж ахуйн нэгжүүдийн хүрээнд хэлэлцүүлгийг зохион байгуулж, нэг удаагийн лиценз олгож нийлүүлэх шийдвэрийг Эмийн зөвлөлөөр гаргуулан худалдан авалтыг хийж ажиллалаа.</p>	100		
-----	-----	--	--	---	-----	--	--

